

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Номгон сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/56/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

НОМГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2022.02.23 № 156

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Номгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Номгон сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц сангаас 38,910,000 төгрөгийн өвс тэжээлийн үнэ, тээврийн зардал шилжүүлснийг шууд зардлаар тусгасан, буцаан төвлөрүүлэх 26,400,000 төгрөгийн өвс тэжээл, буцалтгүй тусламжаар олгосон 1900 боодол өвс, 320 шуудай хивэг, 400 шуудай сүү орлох тэжээлийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦЭРЭНБАЯР

D:\2021 он\Бичиг\Явсан Бичиг\2022-02-23 №156.D

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/
	Эргэлтийн хөрөнгийн дүн	130.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,250.8
	Нийт хөрөнгийн дүн	6,381.5
	Нийт өр төлбөрийн дүн	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,381.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,452.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,158.1
	Үйл ажиллагааны үр дүн	294.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	294.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,087.1
	Тайлант оны үр дүн	294.4
	Эцсийн үлдэгдэл	6,381.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	747.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	723.8
	Үйл ажиллагааны ЦМГ	24.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-24.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	559.5
	Урсгал зардал	559.5
	Хөрөнгийн зардал	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	559.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	559.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Номгон сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилго нь “иргэн төвтэй, хариуцлагатай, ухаалаг удирдлагаар хангаж хүний хөгжлөөр тэргүүлэгч сум болно” гэж тодорхойлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Хандиваар болон эргэн төлөгдөх нөхцөлөөр ирсэн материалыг орлогод аваагүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1,574.5 сая төгрөгийн 138 мэдээллээс 123 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, 15 мэдээлэл буюу 112.2 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудалгүй байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 189.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 186.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

7.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн зардал дансыг орлого үр дүнтэй тулган баталгаажуулахад 2,691,785 төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

7.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангаас 38.9 сая төгрөгийн өвс тэжээлийн үнэ, тээврийн зардал шилжүүлснийг шууд зардалд тусгасан, буцаан төвлөрүүлэх 26.4 сая төгрөгийн өвс тэжээл, буцалтгүй тусламжаар олгосон 1900 боодол өвс, 320 шуудай хивэг, 400 шуудай сүү орлох тэжээлийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, Малчдын урлагийн наадам, тэмээний уралдаан, бөхийн барилдааны наадам зэрэг зардалд 8.5 сая төгрөгийг зарцуулсан, Шилэн дансны мэдээлэлд дараа жилийн төсвийн төсөл, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7 гүйлгээ буюу 45.8 сая төгрөг, 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалт 8 гүйлгээ буюу 66.7 сая төгрөгийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дүгээр зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Засгийн газрын 2021 онд баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

7.3 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.4 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	189.2	1	2.7		-	3	186.5		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	189.2	1	2.7		-	3	186.5		

